



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2022 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/503

Улаанбаатар хот

Эмнэлгийн нөхцөлд эндсэн 5 хүртэлх  
насны хүүхдийн эндэгдэл, амьгүй  
төрөлтийг магадлан хэлэлцэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.13 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эмнэлгийн нөхцөлд эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцэх журам”-ыг нэгдүгээр, “Магадлан хэлэлцэх зөвлөлийн бүрэлдэхүүн, гүйцэтгэх үүрэг”-ийг хоёрдугаар, “Хүүхдийн цогцсыг эмгэг судлалын шинжилгээнд оруулах журам”-ыг гуравдугаар, “Үзүүлэлтийн тодорхойлолт, тооцох аргачлал”-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар ханган, хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар /Ж.Нарангэрэл/-т, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв /Ш.Алтантуяа/-д, Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөл /Т.Болормаа/-д, Эмгэг судлалын үндэсний төв /Г.Уянга/-д тус тус даалгасугай.

3. Тушаалыг мөрдөж ажиллахыг төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын захирал, дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбоотойгоор Эрүүл мэндийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн “Тав хүртэлх насны хүүхдийн эмнэлгийн болон эмнэлгийн бус нөхцөлд эндсэн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцэх тухай” А/503 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141221275  
2022-Tushaal-A

Эрүүл мэндийн сайдын 2022 оны . . . дугаар  
сарын .06.-ны өдрийн . . . дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

ЭМНЭЛГИЙН НӨХЦӨЛД ЭНДСЭН 5 ХҮРТЭЛХ  
НАСНЫ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ,  
АМЬГҮЙ ТӨРӨЛТИЙГ МАГАДЛАН ХЭЛЭЛЦЭХ ЖУРАМ

Нэг: ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Хүүхдийн эндэгдлийг магадлан хэлэлцэх зөвлөлийн хурал нь эмнэлгийн нөхцөлд эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийн тохиолдол бүрт тусламж үйлчилгээг чанартай, зөв үзүүлсэн эсэхийг хянаж, хэлэлцэн, үнэлэлт, дүгнэлт өгөх үйл ажиллагаа юм. Байгууллагын бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө нь зөв боловч хэрэгжих арга зам нь тодорхой бус, мэдлэг, ур чадвар хангалтгүй, гардан ажилбар буруу хийсэн, биеийн байдлыг үнэлж чадаагүй, тушаал, шийдвэр, стандарт, заавар, журам, удирдамж мөрдөөгүй зэрэг удирдлага, зохион байгуулалт, эмнэлгийн тусламж, үйлчилгээний болон эмч, мэргэжилтний мэдлэг, ур чадварын алдаа дутагдлыг дүгнэж, засаж залруулах, шуурхай арга хэмжээ авах, давтагдахаас сэргийлэх тогтолцоог эрүүл мэндийн байгууллага бүр хэрэгжүүлнэ.

Хоёр: ЗОРИЛГО

Магадлан хэлэлцэх зөвлөлийн хурал нь эмнэлгийн нөхцөлд эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтөд нөлөөлсөн шалтгааныг магадлан хэлэлцэж, дүн шинжилгээ хийж, алдаа дутагдлыг давтагдахаас сэргийлэх, цаашид авах арга хэмжээ, зохион байгуулах ажлыг төлөвлөж, тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадварыг тогтмол дээшлүүлэх зорилготой.

Гуграв: МАГАДЛАН ХЭЛЭЛЦЭХ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

3.1. Эрүүл мэндийн байгууллага бүр (ор бүхий улсын болон хувийн хэвшлийн) эмнэлгийн нөхцөлд эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийн тохиолдлыг эмгэг судлалын шинжилгээний дүгнэлт гарснаар эмнэлзүйн хурлыг (дээд шатны байгууллагатай зөвшилцөн, холбогдох мэргэжилтний төлөөллийг оролцуулан) тухай бүрт хийж, материалыг аймаг, дүүргийн эрүүл мэндийн газар /төв/-т ажлын 7 хоногийн дотор цаасан болон цахим хэлбэрээр илгээнэ.

3.2. Эрүүл мэндийн байгууллага бүр эмнэлгийн нөхцөлд эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийн тохиолдлыг магадлан хэлэлцэх зөвлөлийн хурлыг улиралд 1 удаа хийнэ.

3.3. Төр болон хувийн хэвшлийн анхан шатны Эрүүл мэндийн байгууллага (өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эмнэлэг)-д эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийн тохиолдлыг аймаг, дүүргийн Эрүүл мэндийн газар /төв/-т магадлан хэлэлцэнэ.

3.4. Аймаг, дүүргийн Нэгдсэн эмнэлэг, хувийн хэвшлийн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт эндсэн 5 хүртэлх насны хүүхэд, амьгүй төрөлтийн тохиолдлыг байгууллага бүрт магадлан хэлэлцэнэ.

3.5. Зөвлөлийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ.

- Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийн шалтгааныг магадлан хэлэлцэж, дүгнэлт гаргана;
- Нөлөөлсөн хожимдлыг тодорхойлж, үзүүлсэн тусламж, үйлчилгээний чанарт үнэлэлт, дүгнэлт өгч, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг бууруулах талаар шийдвэр гаргана;
- Оношилгоо, эмчилгээтэй холбоотой сургамж, дүгнэлт хийж, зөвлөмж гаргана;
- Дүгнэлтэд үндэслэн асуудлыг хэрхэн шийдвэрлэх арга замыг тогтоож, цаашид зохион байгуулах ажлыг төлөвлөнө;
- Өмнөх хурлаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг үнэлнэ.

3.6. Төрөлжсөн мэргэшлийн төв эмнэлэг нь эмнэлгийн нөхцөлд эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцсэн хурлын тэмдэглэл, зөвлөмж, шийдвэрийг 2 хувиан, хурлаас хойш ажлын 7 хоногийн дотор ЭМЯ-ны Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөл, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (ЭХЭМҮТ)-ийн Тандалт судалгааны албанд албан бичгийн хамт хүргүүлнэ.

3.7. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын харъяа эрүүл мэндийн байгууллагууд нь 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийн тохиолдлыг магадлан хэлэлцсэн хурлын тэмдэглэл, зөвлөмж, шийдвэрийг хурлаас хойш ажлын 7 хоногийн дотор аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлнэ.

3.8. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь харъяа улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн нөхцөлд эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцсэн хурлын шийдвэрт дүн шинжилгээ хийж, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавин, хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг бууруулах талаар мэргэжил аргагүйн дэмжлэг үзүүлж, гарсан дүгнэлт, шийдвэрийг 2 хувиан ЭМЯ-ны Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөл, ЭХЭМҮТ-ийн Тандалт судалгааны албанд улирал тутам албан бичгийн хамт хүргүүлнэ.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 06 -ны өдрийн 4263 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

## МАГАДЛАН ХЭЛЭЛЦЭХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

Нэг: Эмнэлгийн нөхцөлд эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцэх зөвлөлийн бүрэлдэхүүн

### 1.1 Аймгийн Эрүүл мэндийн газар, дүүргийн Эрүүл мэндийн төвд;

Зөвлөлийн дарга: Аймгийн Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга  
Дүүргийн Эрүүл мэндийн төвийн Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга (Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга)

Нарийн бичгийн дарга: Хүүхэд, өсвөр үеийн эрүүл мэндийн асуудал хариуцсан зохицуулагч (Хүүхдийн эндэгдэл хэлэлцэх үед)  
Эх барих эмэгтэйчүүдийн асуудал хариуцсан мэргэжилтэн эсвэл Нөхөн үржихүйн ерөнхий зохицуулагч (нярайн эрт үеийн эндэгдэл, амьгүй төрөлт хэлэлцэх үед)

Гишүүд: Анхан шатны тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн  
Чанарын албаны дарга/чанарын менежер  
Өрхийн менежер  
Сувилахуйн албаны дарга  
Статистикч эмч, мэргэжилтэн  
Шаардлагатай тохиолдолд бусад холбогдох эмч, мэргэжилтэн  
Нэгдсэн эмнэлгийн анатомийн эмгэг судлаач эмч

1.2 Аймаг, дүүргийн Нэгдсэн эмнэлэг, ор бүхий хувийн хэвшлийн хүүхдийн болон төрөх эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг;

Зөвлөлийн дарга: Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга

Нарийн бичгийн дарга: Чанарын албаны дарга, менежер

Гишүүд: Эх барих, эмэгтэйчүүдийн зөвлөх эмч  
Хүүхэд, нярайн зөвлөх эмч  
Холбогдох тасгийн эрхлэгч  
Сувилахуйн албаны дарга  
Статистикч эмч, мэргэжилтэн  
Шаардлагатай тохиолдолд холбогдох эмч, мэргэжилтэн  
Анатомийн эмгэг судлаач эмч (Тохиолдол шийдвэрлэсэн)

### 1.3 Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд;

#### *Хүүхдийн эндэгдэл хэлэлцэх:*

Зөвлөлийн дарга; Эмчилгээ эрхэлсэн дэд захирал (Хүүхдийн эмнэлэг)  
Нарийн бичгийн дарга; Хүүхдийн тусламж, үйлчилгээ хариуцсан чанарын менежер  
Гишүүд; Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын албаны дарга  
Хүүхдийн эмнэлгийн чанарын менежер  
Хүүхдийн тусламж, үйлчилгээний зохицуулагч  
Зөвлөх эмч  
Холбогдох тасгийн эрхлэгч  
Статистик мэдээлэл зүйн тасгийн эрхлэгч, эмч  
Нярайн эндэгдэл хэлэлцэх үед ЭБЭЭ-ийн чанарын менежер болон бусад холбогдох эмч нар  
Шаардлагатай тохиолдолд холбогдох эмч, мэргэжилтэн  
Анатомийн эмгэг судлаач эмч (ЭСҮТ-тэй зөвшилцсөнөөр)

#### *Амьгүй төрөлт хэлэлцэх:*

Зөвлөлийн дарга; Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн дэд захирал  
Нарийн бичгийн дарга; ЭБЭЭ-ийн чанарын менежер  
Гишүүд; ЭБЭЭ-ийн тусламж, үйлчилгээний зохицуулагч  
Холбогдох тасгийн эрхлэгч  
Зөвлөх эмч  
Анатомийн эмгэг судлаач эмч (ЭСҮТ-тэй зөвшилцсөнөөр)  
Шаардлагатай тохиолдолд холбогдох эмч, мэргэжилтэн

### 1.4 Нийслэлийн Эрүүл мэндийн газарт:

Зөвлөлийн дарга: Орлогч дарга  
Нарийн бичгийн дарга: Хүүхэд, нярайн тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн  
Гишүүд: Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга  
Нийслэлийн хүүхэд, нярайн ерөнхий мэргэжилтэн  
Тусламж, үйлчилгээний аюулгүй байдал, эрсдэл, чанарын баталгаажуулалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн  
Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн  
Анхан шатны тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн  
Өсвөр үе, нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн  
Анатомийн эмгэг судлаач эмч (ЭСҮТ-тэй зөвшилцсөнөөр)



Сувилахуйн тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн  
Төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагын мэдээ,  
тайлан хариуцсан мэргэжилтэн  
ЭСҮТ-ийн Хүүхдийн эмгэг судлаач эмч /зөвшилцснөөр/

Хоёр. Магадлан хэлэлцэх зөвлөлийн бүрэлдэхүүний гүйцэтгэх үүрэг

2.1 Харьяа эрүүл мэндийн байгууллага, ор бүхий хувийн хэвшлийн хүүхдийн болон төрөх эмнэлэгт:

- 2.1.1 Зөвлөлийн дарга нь хурлыг удирдан зохион байгуулах, бэлтгэл ажил, шийдвэрт хяналт тавих, холбогдох хууль тогтоомж, түүний хэрэгжилтийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгнө.
- 2.1.2 Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь эмнэлзүй-эмгэг судлалын конференцийн тэмдэглэл, шийдвэрийг хүлээн авч, зөвлөлийн гишүүдэд урьдчилан танилцуулж, хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг гарган, зөвлөлийн даргаар батлуулан, танилцуулна. Хурал зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах ба холбогдох байгууллагад мэдээ тайлан хүргүүлнэ.
- 2.1.3 Зөвлөлийн гишүүд ирүүлсэн материалуудтай бүрэн танилцаж, өөрийн хариуцсан ажлын чиглэлээр үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны зөвлөмжид санал өгөх, өмнөх хурлын шийдвэрийг биелүүлэх, хэрэгжилтийг хангаж, тайлагнана.
- 2.1.4 Статистикч эмч нь бичиг баримт, бүртгэл мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавьж ажиллана.
- 2.1.5 Асуудлыг хурлын төлөвлөгөөний дагуу танилцуулга, асуулт хариулт, санал дүгнэлт, шийдвэр гэсэн дарааллаар хэлэлцэнэ.
- 2.1.6 Хэрэв тусламж, үйлчилгээний ноцтой алдаа, зөрчил гарсан гэж үзсэн тохиолдолд холбогдох эмч, мэргэжилтнийг оролцуулан өргөтгөсөн хэлбэрээр зохион байгуулна.
- 2.1.7 Хурлын тэмдэглэлийг зөвлөлийн нарийн бичгийн дарга хөтлөх бөгөөд хурал удирдагч, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.
- 2.1.8 Хурлын тэмдэглэлд дор дурдсан зүйлс зайлшгүй тусгагдсан байна.
  - Ирцийн байдал /Зөвлөлийн гишүүдийн тоо, хувь, хуралд оролцсон хүмүүсийн овог, нэр, албан тушаал/
  - Хурлын явц, эхэлсэн, дууссан цаг
  - Хурлын дүгнэлт, шийдвэр, сургамж
- 2.1.9 Хурлын шийдвэрийг баримтжуулан, холбогдох удирдлага, эмч, мэргэжилтэнд зөвлөмж өгч, гүйцэтгэлийн хяналт тавьж ажиллана.

2.2 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт:

- 2.2.1 Зөвлөлийн дарга эндэгдлийн хурлыг удирдан зохион байгуулах, бэлтгэл ажил, шийдвэрт хяналт тавина.
- 2.2.2 Хурлыг зөвлөлийн дарга удирдах бөгөөд даргын эзгүйд Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга удирдан явуулна.
- 2.2.3 Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь харьяа эрүүл мэндийн байгууллагаас хурлын тэмдэглэл, шийдвэрийг хүлээн авч, зөвлөлийн гишүүдэд урьдчилан танилцуулж, хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг гарган, зөвлөлийн

- даргаар батлуулан, танилцуулна. Хурал зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах ба холбогдох байгууллагад мэдээ тайлан хүргүүлнэ.
- 2.2.4 Зөвлөлийн гишүүд ирүүлсэн материалуудтай бүрэн танилцаж, өөрийн хариуцсан ажлын чиглэлээр үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны зөвлөмжид санал өгөх, өмнөх хурлын шийдвэрийг биелүүлэх, хэрэгжилтийг хангаж, тайлагнана. Оролцох боломжгүй үед саналаа бичгээр ирүүлнэ.
- 2.2.5 Төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагын мэдээ, тайлан хариуцсан мэргэжилтэн нь бүртгэл, мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавьж ажиллана.
- 2.2.6 Асуудлыг хурлын төлөвлөгөөний дагуу танилцуулга, асуулт хариулт, санал дүгнэлт, шийдвэр гэсэн дарааллаар хэлэлцэнэ.
- 2.2.7 Хэрэв тусламж үйлчилгээний ноцтой алдаа, зөрчил гарсан гэж үзсэн тохиолдолд эрүүл мэндийн байгууллагын холбогдох удирдлага, эмч нарыг оролцуулан өргөтгөсөн хэлбэрээр зохион байгуулна.
- 2.2.8 Хурлын тэмдэглэлийг зөвлөлийн нарийн бичгийн дарга хөтлөх бөгөөд хурал удирдагч, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.
- 2.2.9 Хурлын тэмдэглэлд дор дурдсан зүйлс зайлшгүй тусгагдсан байна.
- Ирцийн байдал /Зөвлөлийн гишүүдийн тоо, хувь, хуралд оролцсон хүмүүсийн овог, нэр, албан тушаал/
  - Хурлын явц, эхэлсэн, дууссан цаг
  - Хурлын дүгнэлт, шийдвэр, сургамж
- 2.2.10 Хурлын шийдвэрийг баримтжуулан, холбогдох эрүүл мэндийн байгууллагад зөвлөмж өгч, мэргэжил аргагүйгээр ханган, гүйцэтгэлийн хяналт тавьна.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 1763 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

## 5 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ЦОГЦСЫГ ЭМГЭГ СУДЛАЛЫН ШИНЖИЛГЭЭНД ОРУУЛАХ ЖУРАМ

Нэг. 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг мэдээлэх

1.1. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар болон дүүргийн Эрүүл мэндийн төвийн статистик эмч нь эмнэлэгт нас барсан 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тохиолдол бүрийг 7 хоногийн Мягмар гараг бүрт ЭХЭМҮТ-ийн Тандалт судалгааны албанд, ЭМХТ-д сар бүрийн 2-3-нд статистик мэдээллийн урсгалын дагуу мэдээлнэ.

1.2. Эмнэлгийн бус нөхцөлд эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тохиолдолд түргэн тусламжийн төвийн дуудлагаар очсон буюу анх мэдсэн эмч хүүхдийн эндэгдлийн тохиолдол бүрийг байгууллагын удирдлагад мэдээлж, тухайн байгууллага 24 цагийн дотор аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын болон дүүргийн Эрүүл мэндийн төвийн хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, статистик эмчид мэдэгдэнэ.

1.3. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын болон дүүргийн Эрүүл мэндийн төвийн хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, статистик эмч эмнэлгийн бус нөхцөлд эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тохиолдлыг 7 хоногийн Мягмар гараг бүрт ЭХЭМҮТ-ийн Тандалт судалгааны албанд, ЭМХТөвд сар бүрийн 02-03-нд статистик мэдээллийн урсгалын дагуу мэдээлнэ.

Хоёр. Эмгэг судлалын шинжилгээнд оруулах

2.1. Эмнэлэгт эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн цогцост анатомийн эмгэг судлаач эмч, үхлийн шалтгаан болон өвчний онош зөв тогтоосон эсэхийг тодорхойлох зорилгоор эмгэг судлалын шинжилгээг хийнэ.

2.2. Эмнэлэгт нас барсан 5 хүртэлх насны хүүхдийн цогцсыг нас барснаас хойш 24 цагийн дотор, дараа өдрийн 12 цагаас өмнө эмгэг судлалын шинжилгээг хийнэ.

2.3. Цогцост эмгэг судлалын шинжилгээг зайлшгүй хийх тохиолдол болон хийхгүй байх тохиолдлыг 2017 оны ЭМС-ын А/55 тоот тушаалын заалтаар зохицуулна.

Гурав. Эмнэлзүй-эмгэг судлалын бага хурал хийх

3.1. Эмгэг судлалын эцсийн онош, дүгнэлт гарснаас хойш ажлын 7 хоногийн дотор байгууллагад суурилсан эмнэлзүйн хурлыг удирдах дээд байгууллагаас холбогдох төлөөлөл, анатомийн эмгэг судлаач эмчийг оролцуулан зохион байгуулна.

3.2. Хурлаар 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан, үзүүлсэн тусламж үйлчилгээний чанарт үнэлэлт дүгнэлт өгч цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал зөвлөмж гаргана.

3.3. Хурлын шийдвэр холбогдох материалыг харьяа магадлан хэлэлцэх зөвлөлд хурлаас хойш ажлын 7 хоногийн дотор хүргүүлнэ.

3.4. Хурлаар хэлэлцвэл зохих асуудлууд:

3.4.1. Үндсэн оношийн зөрөөтэй бүх тохиолдлууд

3.4.2. Эмчилгээ үйлчилгээний дутагдал, ноцтой тохиолдол, хожимдол-3 гэж тодорхойлогдсон бүх тохиолдлууд

3.4.3. Эмгэг судлалын шинжилгээгээр онош бүрэн тавигдаагүй тохиолдлууд

3.4.4. Сургалтын болон эмчилгээний холбогдолтой ховор тохиолдлууд



Эрүүл мэндийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 06 -ны өдрийн 17/203 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт



## ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТООЦОХ АРГАЧЛАЛ

Нэг. Тодорхойлолт

**Амьгүй төрөлт:** Жирэмсний 22 долоо хоног ба түүнээс хойшх хугацаанд 500 гр-аас дээш жинтэй төрсөн нярайд амьдын шинж тэмдгийн аль нь ч (амьсгал, зүрхний цохилт, хүйн судасны лугшилт, булчингийн хөдөлгөөн) илрэхгүй байвал амьгүй төрөлтөд тооцно.

**Нярай үе:** Төрсөн цагаас эхэлж төрсний дараах 28 бүтэн хоног дуусах хүртэл үргэлжилдэг хугацаа.

**Перинатал үе:** Жирэмсний бүтэн 22 долоо хоног (154 өдөр)-с эхэлж (энэ үед ургийн жин 500 грамм байна) төрсний дараах 7 хоног хүртэл үргэлжилдэг хугацаа.

**Нярайн эндэгдэл:** Амьдралын эхний бүтэн 28 хоног дотор нярайн эндэгдэл.

**Нярайн эрт үеийн эндэгдэл:** Төрсний дараах эхний 7 хоног доторх эндэгдэл.

**Нярайн хожуу үеийн эндэгдэл:** Төрсний дараах 7 дахь хоногоос хойш боловч бүтэн 28 хоног дуусах хүртэлх хугацаанд тохиолдсон эндэгдэл.

**Нэг хүртэлх насны (нялхсын) хүүхэд:** 0-364 хоногтой хүүхэд.

**Тав хүртэлх насны хүүхэд:** 0-4 нас, 364 хоногтой хүүхэд.

**Эмнэлгийн бус нөхцөлд эндсэн эндэгдэл:** Хүүхэд эмнэлгээс бусад газарт эндсэн тохиолдол бүрийг хэлнэ.

Хоёр. Үзүүлэлт тооцох аргачлал

### 2.1. Амьгүй төрөлтийн түвшин:

Тайлангийн хугацаанд бүртгэгдсэн амьгүй төрөлтийн тоог 1000 нийт төрөлтөд харьцуулсан үзүүлэлт. (Нийт төрөлт=амьд+амьгүй)

Амьгүй төрөлтийн тоог 1000 нийт төрөлтөд харьцуулан доорх томъёог ашиглан тооцно.

$$\text{Амьгүй төрөлтийн түвшин} = \frac{\text{Амьгүй төрөлтийн тоо} * 1000}{\text{Нийт төрөлтийн тоо}}$$

**2.2. Нярайн эндэгдлийн түвшин:** Төрсний дараах 28 хоногийн дотор эндсэн хүүхдийн тоог 1000 амьд төрөлтөд харьцуулсан үзүүлэлт.

Нярайн эндэгдлийг 1000 амьд төрөлтөд харьцуулан доорх томъёог ашиглан тооцно.

$$\text{Нярайн эндэгдлийн түвшин} = \frac{\text{Төрсний дараах 28 хоногийн дотор эндсэн нярайн тоо} * 1000}{\text{Амьд төрөлтийн тоо}}$$

**2.2.1. Нярайн эрт үеийн эндэгдлийн түвшин:** Төрсний дараах эхний 7 хоног дотор эндсэн нярайн тоог 1000 амьд төрөлтөд харьцуулсан үзүүлэлт.

Нярайн **эрт үеийн** эндэгдлийг 1000 амьд төрөлтөд харьцуулан доорх томъёог ашиглан тооцно.

$$\text{Нярайн эрт үеийн эндэгдлийн түвшин} = \frac{\text{Төрсний дараах 7 хоногийн дотор эндсэн нярайн тоо} * 1000}{\text{Амьд төрөлтийн тоо}}$$

**2.2.2. Нярайн хожуу үеийн эндэгдлийн түвшин:** Төрсний дараах 7-28 хоног дотор эндсэн нярайн тоог 1000 амьд төрөлтөд харьцуулсан үзүүлэлт.

Нярайн **хожуу үеийн** эндэгдлийг 1000 амьд төрөлтөд харьцуулан доорх томъёог ашиглан тооцно.

$$\text{Нярайн хожуу үеийн эндэгдлийн түвшин} = \frac{\text{Төрсний дараах 7 – 28 хоногийн дотор эндсэн нярайн тоо} * 1000}{\text{Амьд төрөлтийн тоо}}$$

**2.3. Нэг хүртэлх насны хүүхдийн (нялхсын) эндэгдлийн түвшин:** Тайлангийн жилд эндсэн 1 хүртэлх насны хүүхдийн тоог 1000 амьд төрөлтөд харьцуулсан үзүүлэлт.

Нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1000 амьд төрөлтөд харьцуулан доорх томъёог ашиглан тооцно.

$$\text{Нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин} = \frac{\text{Нас барсан 1 хүртэлх насны хүүхдийн тоо} * 1000}{\text{Амьд төрөлтийн тоо}}$$

**2.4. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин:** Тайлангийн жилд эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн тоог 1000 амьд төрөлтөд харьцуулсан үзүүлэлт.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1000 амьд төрөлтөд харьцуулан доорх томъёог ашиглан тооцно.

$$\text{Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин} = \frac{\text{Нас барсан 5 хүртэлх насны хүүхдийн тоо} * 1000}{\text{Амьд төрөлтийн тоо}}$$

ooOOoo